



**МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан  
спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн  
тэмцээний удирдамж**

2026 оны 05 сарын 29 нөөс 2026 оны 06 сарын 1

Монгол улс  
Улаанбаатар хот

---

## АГУУЛГА

1. Тэмцээний мэдээлэл
2. Ерөнхий мэдээлэл
3. Насны ангилал
4. Тэмцээний бүртгэл
5. Медаль, гэрчилгээ
6. Нэмэлт урамшуулалын хөтөлбөр
7. Тэмцээний байршил
8. Бие халаалалтийн заавар
9. Эсэргүүцэл
10. Тэмцээний төрөл
11. Тэмцээний хөтөлбөр
12. Тэмцээний хувцас, хэрэглэл, сурталчилгаа
13. Тэмцээнд оролцогчдын ёс зүйн хэм хэмжээ
14. Тамирчны харъяалал, байгууллага клубыг төлөөлөх эрх
15. Тамирчны хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам

## ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО

“Сэлэм загас” Усан спортын клубын

Удирдах зөвдөл

Ерөнхий шүүгч



*Х. Батболд*

/Х.Батболд /

/ М.Аюуш /

## **1. ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Тэмцээн: МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээн

Эхлэх, дуусах, он, сар, өдөр: 2026.05.29 - 2026.06.01

Он сар өдөр	Гараг	Цагийн хуваарь	
		13-18 нас, 19 +	7-12 нас
2026.05.29	Баасан	09:00	15:00
2026.05.30	Бямба	09:00	15:00
2026.05.31	Ням	09:00	15:00
2026.06.01	Даваа	09:00	15:00

## **2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

- 2.1.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усанд сэлэлтийн клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээн нь “МУССХ-ны Тэмцээний дүрэм”-ийн дагуу явагдана.
- 2.2.Тэмцээнийг ганцаарчилсан төрлөөр зохион байгуулна.
- 2.3.Тэмцээнд оролцогч тамирчдыг саналын дагуу ОУ-ын Найрамдал цогцолборт 1 дүгээр ээлжээр бүртгэх бөгөөд 2026 оны 05 дугаар сарын 28-ны өглөө нэгдсэн байдлаар Номин Драгон төв дээрээс Автобусаар үйлчилнэ. Мөн 2026 оны 6 сарын 2-ны өглөө Номин Драгон төв дээр үдэн гаргана.
- 2.4.ОУ-ын Найрамдал цогцолбор дээр байрлаж байгаа тамирчид 5 дугаар сарын 28 ны өдрөөс 6 дугаар сарын 1 ны өдрийг дуустал тэмцээний бие халаалт болон тэмцээний хөтөлбөрийн дагуу автобусаар үйлчилнэ.
- 2.5.Тамирчид ОУ-ын Найрамдал цогцолборийн дотоод дүрэм журмын чандлан сахих ба тэмцээн болон бие халаалтын үед тэмцээний удирдамжын дагуу явагдана.
- 2.6.ОУ-ын Найрамдал цогцолборийн нийт суудлын 500-600 ба Олон улсын тамирчид болон Орон нутгийн тамирчдыг тэргүүн эгнээн байршуулна. Үлдсэн суудлын тоог хамгийн түрүүнд бүртгүүлсэн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг багуудад олгоно. Багууд байршуулах тамирчдын тоо түүнтэй тэнцэх төлбөрөөр суудал баталгаажуулна.
- 2.7.ОУ-ын Найрамдал цогцолборийн төлбөр 5 хоногийн байр, өдрийн 3 хоол, угтах болон үдэх автабус үйлчилгээ, тэмцээний үеийн автабус үйлчилгээ, мандат зэрэг багтсан.

- 2.8.ОУ-ын Найрамдал цогцолборт байрших багууд 2 хүртэлх багш байршуулах боломжтой ба багш нарын төлбөр хүүхдийн төлбөртэй адил байна.
- 2.9.ОУ-ын Найрамдал цогцолбор Бүлгийн багш гаргаж өгөх ба багуудаас байршиж буй багш нар бүлгийн багштай нягт хамтран ажиллана.
- 2.10. ОУ-ын Найрамдал цогцолборт байрших багш тамирчдад мандат олгох ба мандатыг бусдад дамжуулахыг хатуу хориглоно. Хэрэв бусдад дамжуулсан нь нотлогдвол тэмцээн болон хотхоныг бүрэн орхино. Төлбөрийг буцаан олгохгүй.
- 2.11. Мандатыг гээгдүүлсэн тохиолдолд 20000 торгуультай.
- 2.12. ОУ-ын Найрамдал цогцолборт байрших тамирчид Харьяа Эрүүл Мэндийн төвд Эрүүл мэндийн тодорхойлолтын хуудас заавал бүрдүүлнэ.
- 2.13. ОУ-ын Найрамдал цогцолборт байрших тамирчид эцэг эх /асран хамгаалагч/-ийн зөвшөөрлийн хуудасыг заавал бөглүүлнэ.
- 2.14. ОУ-ын Найрамдал цогцолборт оруулахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт, Эрүүл мэндийн тодорхойлолтын хуудас, Эцэг, эх /асран хамгаалагч/-ийн зөвшөөрлын хуудсыг хавсралтаас үзнэ үү.

### **3. НАСНЫ АНГИЛАЛ**

- 3.1. Насны бүлэг: 7 нас, 8 нас, 9 нас, 10 нас, 11 нас, 12 нас, 13 нас, 14 нас, 15 нас, 16 нас, 17 нас, 18 нас, 19+
- 3.2. Насны бүлгийг 2026 оны 12 сарын 31-ний өдрөөр тооцно.
- 3.3.Тамирчид зөвхөн өөрийн насны бүлэгт өрсөлдөнө.
- 3.4.Зохион байгуулагчид тамирчны бичиг баримтыг шаардаж, насны бүлгийг баталгаажуулан шалгах эрхтэй бөгөөд зөрчил гарсан тохиолдолд тэмцээнээс хасах арга хэмжээг авч, Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн хариуцлага тооцуулна.

Насны бүлэг	Төрсөн он
7 нас	2019 он
8 нас	2018 он
9 нас	2017 он
10 нас	2016 он
11 нас	2015 он
12 нас	2014 он

Насны бүлэг	Төрсөн он
13 нас	2013 он
14 нас	2012 он
15 нас	2011 он
16 нас	2010 он
17 нас	2009 он
18 нас	2008 он
19+	2007 он -

#### 4. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

4.1. Доорхи шаардлагыг хангасан клуб, тамирчин тэмцээнд оролцох эрхтэй.

Тэмцээний бүртгэлийн хураамж төлсөн байх.

Тэмцээнд уралдах төрөл, зай тус бүрт 10000 төгрөг.

Тэмцээний хураамжийг: 84003200 5005997588 Хас банк “Сэлэм загас” усан спортын клуб ТББ 2026 оны 05 сарын 15 өдрийн дотор багийн ахлагч болон дасгалжуулагч нар нь оролцох тамирчдын нэрсийг нэгтгэн нэгдсэн байдлаар нэг гүйлгээ хийнэ.

4.2. Тэмцээний бүртгэл 2025 оны 04 дугаар сарын 22-ны өдрөөс нээгдэх бөгөөд 2025 оны 05 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал бүртгэнэ.

4.3. Бүртгэлийн хураамжаа төлж, мэдүүлгээ тогтоосон хугацаанд гаргасан бүх баг тамирчид тэмцээнд оролцох эрхтэй.

4.4. Тэмцээний бүртгэлийн хуудсыг 2026 оны 05 дугаар сарын 15-ны 23.59 цагас өмнө [bdr.ariunsukh@gmail.com](mailto:bdr.ariunsukh@gmail.com) цахим шуудангаар илгээсэн байх шаардлагатай.

4.5. Клуб, багийн ахлагчид хавсралтаар илгээсэн EXCEL файлыг нэгдсэн байдлаар бөглөж нийт тамирчдынхаа мэдүүлгийг өгнө. Мэдүүлэг бөглөх заавар:

NATION	CLUBNAME	FIRSTNAME	LASTNAME	GENDER	BIRTHDATE	STROKE	DISTANCE	ENTRYTIME
MGL	Individual	Erdenebileg	Erdenebayar	M	1/22/2010	Free	50	33.00
MGL	Individual	Erdenebileg	Erdenebayar	M	1/22/2010	Free	100	01:15.01
MGL	Selem Zagas	Misheel	Ganbaatar	F	7/6/2011	Breast	50	52.20
MGL	Selem Zagas	Misheel	Ganbaatar	F	7/6/2011	Breast	100	1.59.51
MGL	Selem Zagas	Tsogtbaatar	Manlai	M	6/25/2011	Free	50	42.00
MGL	Selem Zagas	Tsogtbaatar	Manlai	M	6/25/2011	Breast	50	NT
<b>MGL</b>	<b>Клубын нэр</b>	<b>Тамирчны нэр</b>	<b>Тамирчны овог</b>	<b>Хүйс</b>	<b>Сар/Өдөр/Он</b>	<b>Сэлэлт төрөл</b>	<b>Зай</b>	<b>Мин:Сек.Доль</b>

4.6. Бүртгэлийн хураамжаа төлж, мэдүүлгээ тогтоосон хугацаанд гаргасан бүх баг тамирчид тэмцээнд оролцох эрхтэй.

4.7. Бүртгэл хаагдахаас өмнө тамирчид зай төрөл нэмж болно. Харин зай төрөл өөрчлөх, хасах боломжгүй.

4.8. Ямар нэгэн шалтгаанаар тэмцээнд оролцох боломжгүй болсон, бүртгэл хаагдсаны дараа гараагаа хасуулсан тамирчдын гарааны хураамжийг буцаан олгох боломжгүй.

4.9. Техникийн зөвөлгөөнд бүх багийн ахлагчид оролцох үүрэгтэй.

4.10. Тэмцээнд оролцогчдын гарааны дараалал, хуваарийг тэмцээн эхлэхээс 7 хоногийн өмнө нийтэлнэ.

4.11. Багийн ахлагч нар гарааны хуваарь гарсны дараа өөрийн багийн тамирчдын бүртгэлийг нягтлан шалгаж, ямар нэг алдаа гарсан байвал яаралтай зохион байгуулагчдад мэдэгдэх үүрэгтэй.

4.12. Багийн ахлагч, дасгалжуулагч нар нь багийнхаа тэмцээнд оролцохын өмнөх аюулгүй байдал, хариуцлагын журам, заавартай танилцах үүрэгтэй.

## **5. МЕДАЛЬ, ГЭРЧИЛГЭЭ**

5.1.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээний шагналыг дараах байдлаар олгоно.

5.2.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээний насны ангилал тус бүрд эхний гурван байранд орсон тамирчдад

<b>Алт</b>	<b>Мөнгө</b>	<b>Хүрэл</b>
<b>25000₮</b>	<b>20000₮</b>	<b>15000₮</b>

5.3.Тамирчид ижил цагийн амжилт үзүүлсэн бол медалийг доорхи байдлаар олгоно.

Нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол:

2 Алт            1 Мөнгө            1 Хүрэл

Хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт            2 Мөнгө            1 Хүрэл

Гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт            1 Мөнгө            2 Хүрэл

Хэрэв 3 тамирчин ижил цагийн амжилт гаргасан бол медалийг доорхи байдлаар олгоно.

Нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол:

3 Алт            1 Мөнгө            1 Хүрэл

Хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт            3 Мөнгө            1 Хүрэл

Гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт            1 Мөнгө            3 Хүрэл

5.4.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээнд оролцогч тамирчин тус бүрт дурсгалын зүйл хадгалуулна.

/Техникийн зөвөлгөөн дээр/

5.5.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээнд оролцогч тамирчин тус бүрийн гарааны хувийн амжилтыг бататгасан Гэрчилгээг цахимаар олгоно. /Тэмцээн дууссанаас хойш/

5.6.Тэмцээнд оролцсон багуудад дурсгалын зүйл хадгалуулна. /Техникийн зөвөлгөөн дээр/

## **6. НЭМЭЛТ УРАМШУУЛАЛЫН ХӨТӨЛБӨР**

6.1.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээнд оролцогч тамирчин нь Монгол Улсын Рекорд амжилтийг шинэчлэн тогтоосон бол зохион байгуулагч Сэлэм загас клубын зүгээс Сертификат, 100000 төгрөгийн мөнгөн шагналаар урамшуулна.

6.2.МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын нэрэмжит усанд сэлэлтийн тэмцээнд оролцогч тамирчин нь МУССХ-ны баталсан зэрэг цолны болзол хангасан тохиолдолд зохион байгуулагч Сэлэм загас клубын зүгээс дараах урамшуулалыг олгоно. Үүнд:

6.2..1. Дэд мастерийн болзол хангасан тохиолдолд Сертификат, 100000 төгрөг

6.2..2. Мастерийн болзол хангасан тохиолдолд Сертификат, 150000 төгрөг

6.2..3. Олон улсын хэмжээний Мастерийн болзол хангасан тохиолдолд Сертификат, 200000 төгрөг

6.3.Дээрхи урамшуулалын хөтөлбөр нь Монгол улсын иргэн, МУССХ-ны гишүүн байгууллагуулагуудад харьяалагддаг тамирчдад олгогдох бөгөөд зөвхөн амжилт тус бүрт нэг удаа олгогдох урамшуулал юм.

6.4.Урамшуулалыг МУССХ-ны жилийн эцсийн тайлангийн хурал дээр МУССХ-ны гишүүн “Сэлэм загас” Усан спортын клубын зүгээс олгоно.

## **7. ТЭМЦЭЭНИЙ БАЙРШИЛ**


7.1.Тэмцээн: Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 34-р хороо Спорт Цогцолбор. Утас: 77171167

7.2.Тэмцээнд оролцогч баг тамирчдыг дасгалжуулагчдын хамт Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт байршуулна.

7.3.Зохион байгуулагч: Утас: 91310707, 99773773

## 8. БИЕ ХАЛААЛТЫН ЗААВАР

- 8.1. Тэмцээн эхлэхээс 90 минутын өмнө тамирчдын бие халаалт эхлэнэ.
- 8.2. Бие халаалтийн хуваарийг техникийн зөвлөгөөн дээр сугалаагаар тохируулах бөгөөд ОУ-ын Найрамдал цогцолбор дээр байрлах тамирчдыг цагийн хуваарын дагуу автобусаар үйлчилнэ.
- 8.3. Бие халаалтын журмын биелэлтийг Ерөнхий шүүгч хянаж ажиллана.
- 8.4. Бие халаалтийг зургаар үзүүлнэ. Бие халаалтийн зааврчилгаа болон журмийг зөрчсөн баг тамирчдыг сануулах, давтсан тохиолдолд бие халаалтийг зогсооно.
- 8.5. Баг тамирчид зөвхөн зохион байгуулагчдын гаргасан хуваарийн дагуу халаалтаа хийх бөгөөд багийн ахлагчид хяналт тавих үүрэгтэй. Бие халаалтийг оноогдсон цагийн хуваарын дагуу хийх, хоцорсон тохиолдолд нөхөхгүй болно.
- 8.6. Тамирчид усан сангийн ирмэг дээр суусан байрлалаас хөлөөрөө ус руу орно. Ус руу үсэрч орохыг хатуу хориглоно.
- 8.7. Бие халаалтын үндсэн замуудыг доорхи зурагт үзүүлсний дагуу тойрог хэлбэрээр хоёр чиглэлд сэлэхэд ашиглах бөгөөд тус замд шумбалт хийхийг хориглоно.
- 8.8. Хурдтай сэлэлтийн болон араар даллах сэлэлтийн замыг нэг чиглэлд ашиглах бөгөөд зөвхөн энэ замд шумбалт хийхийг зөвшөөрнө.
- 8.9. Бие халаалтын үед сэлүүр ашиглахыг хориглоно.
- 8.10. Дасгалжуулагчид бие халаалтын журам болон аюулгүй байдлын зааварчилгааг тамирчиддаа өгөх үүрэгтэй бөгөөд бие халаалтын үеэр байнга хамт байж аюулгүй байдалд нь хяналт тавина. Бусад багуудын халаалтын цаг болоход тамирчдаа усан сангаас даруй гаргах үүрэгтэй.
- 8.11. Автомат цагийн мэдрэгч хавтан суурьлуулсан талаар усан сангаас гарах тамирчид зөвхөн хажуу талын хананы дагуу усан сангаас гарна.
- 8.12. Бие халаалтын журам зөрчсөн тамирчныг Ерөнхий шүүгч болон тэмцээний зохион байгуулагчид усан сангаас нэн даруй гаргана.
- 8.13. Тэмцээн эхлэхээс 15 минутын өмнө усан бассейныг чөлөөлнө.
- 8.14. Нэг ба Тав дугаар зам дээр үсрэлт эргэлтийг хийнэ. 2, 3, 4 дүгээр зам дээр бие халаалт хийнэ.



## 8. ЭСЭРГҮҮЦЭЛ

8.14. Эсэргүүцэл илэрхийлэх боломжтой.

8.15. Эсэргүүцлийг доорхи тохиолдолд гаргаж болно.

- а. Тэмцээний дүрэм, зохион байгуулах журам тодорхой биш
- б. Тамирчдад ямар нэг эрсдэл үүссэн бол
- в. Шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэж болно. Гэвч баримтад тулгуурласан шийдвэрийг эсэргүүцэхийг хориглоно.

8.16. Эсэргүүцлийг мэдүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- а. Ерөнхий шүүгчид мэдүүлэх
- б. Тэмцээн зохион байгуулагчдад мэдүүлэх
- в. Тухайн уралдаан болсноос хойш 30 минутын дотор

8.17. Дүрмийн дагуу мэдүүлсэн эсэргүүцлийг дараагийн үйл ажиллагаа болон тэмцээний гараа эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.

8.18. Бүх эсэргүүцлийг Ерөнхий шүүгч хянаж шийдвэрлэнэ. Ерөнхий шүүгч эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гаргасан бол шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.

**9. ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ, ЗАЙ**

	Өврөөр даллах 50м	Өврөөр даллах 100м	Араар даллах 50м	Араар даллах 100м	Мэлхий сэлэлт 50м	Мэлхий сэлэлт 100м	Далайн гахай сэлэлт 50м	Далайн гахай сэлэлт 100м	Холимог сэлэлт 100м
7 нас	+		+		+		+		
8 нас	+		+		+		+	+	+
9 нас	+	+	+	+	+	+	+	+	+
10 нас	+	+	+	+	+	+	+	+	+
11 нас	+	+	+	+	+	+	+	+	+
12 нас	+	+	+	+	+	+	+	+	+
13 нас	+	+	+	+	+	+	+	+	+
14 нас	+	+	+	+	+	+	+	+	+
15 нас	+	+	+	+	+	+	+	+	+
16 нас	+	+	+	+	+	+	+	+	+
17 нас	+	+	+	+	+	+	+	+	+
18 нас	+	+	+	+	+	+	+	+	+
19+	+	+	+	+	+	+	+	+	+

**10. ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

2026 оны 05 сарын 29			
09:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	50м	Мэлхий сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
2	100м	Өврөөр даллах сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
15:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	50м	Мэлхий сэлэлт /эм, эр/	7, 8, 9, 10, 11, 12
2	100м	Өврөөр даллах сэлэлт /эм, эр/	9, 10, 11, 12
2026 оны 05 сарын 30			
09:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	100м	Араар даллах сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
2	50м	Далайн гахай сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
3	100м	Холимог сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
15:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	100м	Араар даллах сэлэлт /эм, эр/	9, 10, 11, 12
2	50м	Далайн гахай сэлэлт /эм, эр/	7, 8, 9, 10, 11, 12
3	100м	Холимог сэлэлт /эм, эр/	8, 9, 10, 11, 12
2026 оны 05 сарын 31			
09:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	50м	Өврөөр даллах сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
2	100м	Далайн гахай сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
15:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	50м	Өврөөр даллах сэлэлт /эм, эр/	7, 8, 9, 10, 11, 12
2	100м	Далайн гахай сэлэлт /эм, эр/	9, 10, 11, 12
2026 оны 06 сарын 1			
09:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	50м	Араар даллах сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
2	100м	Мэлхий сэлэлт /эм, эр/	13, 14, 15, 16, 17, 18, 19+
14:00 цаг			
№	Зай	Төрөл	Нас
1	50м	Араар даллах сэлэлт /эм, эр/	7, 8, 9, 10, 11, 12
2	100м	Мэлхий сэлэлт /эм, эр/	9, 10, 11, 12

## **11. ТЭМЦЭЭНИЙ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ, СУРТАЛЧИЛГАА**

- 11.14. Усанд сэлэлтийн тэмцээний эрэгтэй усны хувцасны дээд хэсэг хүйснээс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Эмэгтэйчүүдийн хувьд усны хувцас нь хүзүүг халхалж, дээд хэсэг мөрнөөс дээш, доод хэсэг өвдөгнөөс доош байж болохгүй. Усны хувцас нь нэхмэл материалаар хийгдсэн байх ёстой.
- 11.15. Усны өмсгөлийн өнгө тунгалаг /гэрэлтэж харагддаг/ байж болохгүй. Хоёр давхар малгай өмсөж болно.
- 11.16. Тамирчны малгай, шил нь усанд сэлэлтийн төрөлд тохирсон байх бөгөөд ямар нэгэн сөрөг сэтгэгдэл төрүүлэх тэмдэг, тэмдэглэгээгүй байна.
- 11.17. Тэмцээний үеэр тамирчин хурд, хөвөх чадвар, тэсвэр хатуужилд нь туслах ямар нэгэн төхөөрөмж, усны хувцас ашиглахыг хориглоно.
- 11.18. Гэмтлийн улмаас хоёроос илүүгүй хөлийн хурууг нааж болно. Ерөнхий шүүгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд тамирчин бие дээрээ ямар нэгэн наалт наахыг хориглоно.
- 11.19. Тэмцээний рекорд амжилтыг зөвшөөрөгдсөн усан сэлэлтийн хувцас хэрэглэсэн тохиолдолд л МУССХ хүлээн зөвшөөрнө.
- 11.20. Тэмцээний тухайн төрөл, зайны шагнал гардуулах ёслолыг дараагийн төрөл, зайны тэмцээн явагдаж байх хооронд 2 давхарт олгоно. Шагнал гардуулалтанд зөвхөн медаль болон мөнгөн шагналыг олгоно.
- 11.21. Утаат тамхи, электрон тамхи болон согтууруулах ундааны сурталчилгааг хориглоно. Мөн хэрэглэхийг хориглоно.
- 11.22. Бие дээрх ямар нэгэн таних тэмдэг, сурталчилгааг хориглоно.
- 11.23. Тамирчны харъяалагдах байгууллага, клубын нэр болон таних тэмдгийг зар сурталчилгаанд тооцохгүй.
- 11.24. Энэхүү дүрмийн ерөнхий шаардлагыг илт зөрчсөн хувцас хэрэглэлтэй тамирчинд Ерөнхий шүүгч зөрчлийг арилгах шаардлага тавих бөгөөд шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тэмцээнээс хасах эрхтэй.

## **12. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ**

- 12.14. Тэмцээнд оролцогч тамирчид, дасгалжуулагчид, баг хамт олон, эцэг эхчүүд болон хөгжөөн дэмжигчид доорхи ёс зүйн хэм хэмжээг баримтална. Үүнд:

12.14.1. Үнэнч шударгаар өрсөлдөж, ёс зүйн аливаа зөрчил гаргахаас зайлсхийх

- 12.14.2. Усан спортыг гутаан доромжлох, усан спорт болон МУССХ-ны нэр хүндийг унагаах үйлдэл, эс үйлдэл хийхээс зайлсхийх.
- 12.14.3. Тэмцээн зохион байгуулагчид болон тамирчид, хэвлэл мэдээлэл болон үзэгчдийн эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, үл хүндэтгэсэн зан авир гаргахгүй байх.
- 12.14.4. Бусдыг үндэс угсаа, арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, хэл соёл, хувийн үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас зайлсхийх.
- 12.14.5. Тэмцээний үйл ажиллагаа, зохион байгуулалтад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, тогтоосон дэгийг зөрчихгүй байх. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.
- 12.14.6. Тэмцээний бүхий л үйл ажиллагаа болон шагнал гардуулах ёслолд идэвхтэй оролцоно.
- 12.14.7. Сэргээшийн эсрэг хөтөбөрийг дэмжиж, дэлхийн сэргээшийн эсрэг дүрмээр хориглосон ямар нэг бэлдмэл, зан үйл ашиглахгүй байх.
- 12.14.8. Согтууруулах ундаа, утаат болон электрон тамхи хэрэглэхийг хатуу хориглоно. Энэ заалт нь усан сангийн бүх хэсэг болон тухайн арга хэмжээний гадна талбайд болсон зөрчилд ч хамаарна.
- 12.14.9. Тамирчдын насыг санаатайгаар буруу мэдээлэх, холбогдох баримтыг засварлах, хуурамчаар үйлдэхгүй байх.
- 12.15. Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдлийг тэмцээнийг зохион байгуулах хороонд мэдэгдэж хамтран ажиллах

### **13. ТАМИРЧНЫ ХАРЪЯАЛАЛ, БАЙГУУЛЛАГА КЛУБЫГ ТӨЛӨӨЛӨХ ЭРХ**

- 13.14. Тамирчин МУССХ-ны гишүүн байгууллага, клуб болон хамтран ажилладаг байгууллагыг төлөөлж оролцохоос гадна хуваараа оролцож болно. Аливаа байгууллага клубыг төлөөлөн оролцохын тулд тамирчин нь тухайн байгууллага, клубынхаа гишүүн байх шаардлагатай.